

БАТЛАВ.
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

Ч.МӨНХТУЯА

БАТЛАВ
МОНГОЛЫН ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗРЫН
ТОСНЫ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛҮДИЙН ХОЛБООНЫ ДАРГА

М.БОЛДСАЙХАН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДАД 2024-2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХАМТЫН ГЭРЭЭ

2024 оны 06 дугаар
сарын 27 ны өдөр


Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ конвенци, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг үндэслэн нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газрын захиргаа (цаашид "ажил олгогч" гэх), нөгөө талаас нийт ажилтныг төлөөлж, ҮЭ-ийн хороодын төлөөлөл (цаашид "ажилтны төлөөлөгч", хамтад нь "талууд" гэх) харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Гэрээний хугацаа дуусахад шинээр гэрээ байгуулаагүй, нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол дараагийн гэрээг байгуулах хүртэлх хугацаанд энэхүү гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.3. Талууд хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд бичгээр гаргаж, тухайн үед хэлэлцэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 1.4. Талууд гэрээнд заасан аливаа асуудалд тэгш эрхтэй оролцоно.
- 1.5. Хамтын гэрээг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулна.
- 1.6. Ажилтны төлөөлөгч хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг биелүүлэх талаар шаардлага тавьж хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх эрхийг эдэлнэ.
- 1.7. Ажил олгогчийн харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй бөгөөд хэрэгжилтийг хангах үүргийг гэрээний талууд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.8. Хамтын гэрээнд талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, харьяа байгуулага, алба, орон нутгийн нисэх буудлуудад хүргүүлэх, сурталчлах үүргийг гэрээний талууд хамтран хэрэгжүүлнэ.
- 1.9. Талууд хамтын гэрээг байгуулахдаа цаашид улам бүр сайжруулан боловсронгуй болгох зарчмыг баримтална.
- 1.10. Энэхүү хамтын гэрээ нь зөвхөн Үйлдвэрчний эвлэлийн гишүүдэд үйлчилнэ.

Хоёр. Цалин хөлс

2.1. Ажил олгогч нь ажилтантай тохиролцож, ажил албан тушаал хавсран ба хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны ажил үүргийг орон хүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож нэмэгдэл олгоно.

БҮРТГЭЛ 91


2.2. Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг 2.0 дахин нэмэгдүүлж олгоно.

2.3. Долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно.

2.4. Батлагдсан хуваарийн дагуу ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын өдөр тааран ажиллаж, дараа өдөр ажилласан хугацаагаар нь биечлэн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно.

2.5. Ээлжээр ажилладаг ажилтны ээлж нийтээр амрах баярын өдөр тааран ажиллаж дараа өдөр ажилласан хугацаагаар нь биечлэн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 2.0 дахин нэмэгдүүлж олгоно.

2.6. Ээлжийн ажилтнуудын шөнийн нэг цагийн нэмэгдэл хөлсийг хэвийн нөхцөлд ажиллагсдад 2,000 (хоёр мянга), хэвийн бус нөхцөлд ажиллагсдад 4,000 (дөрвөн мянга) төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тооцож олгоно.

2.7. Цалинг сард 2 удаа олгох бөгөөд сар бүрийн 13, 26-ны өдөр олгоно. (Тухайн нэгж албан ажлын онцлогийг харгалзан хугацааг өөрөөр тогтоон мөрдөж болно.)

2.8. ИНЕГ, ИНУТ, түүний харьяа салбар, нэгжийн ажилтнуудад хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгоно. Хөдөлмөрийн нөхцөлийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр хэвийн бус нөхцөлд ажилладаг ажиллагсдад батлагдсан цалингийн санд багтаан үндсэн цалингийн 10 хувиар бодож нэмэгдэл хөлс олгоно.

2.9. Зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт болон ажлын шаардлагаар өөр ажил, албан тушаалд ажиллуулсны улмаас цалин буурсан ажилтанд өмнөх албан тушаалын үндсэн цалинг 6 сарын хугацаанд үргэлжлүүлэн олгох ба хөдөлмөрийн гэрээнд тусгаж баталгаажуулсан байна.

2.10. Ажилтныг удаан жил, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор ИНЕГ, ИНУТ, түүний харьяа салбар, нэгж болон иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаа эрхлэгч байгууллага (Төрийн захиргааны төв байгууллагын иргэний нисэхийн асуудал хариуцсан нэгж, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага)-д ажилласан хугацаанаас хамаарч "удаан жил ажилласны цалингийн нэмэгдэл"-ийг олгоно. Удаан жил ажилласны цалингийн нэмэгдлийг ажилтны сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар тооцож олгоно. Үүнд:

- 2.10.1. 2 дахь жил (13-24 сар) -1 хувь
- 2.10.2. 3 дахь жил (25-36 сар) -2 хувь
- 2.10.3. 4 дэх жил (37- 48 сар) -3 хувь
- 2.10.4. 5 дахь жил (49-60 сар) -4 хувь
- 2.10.5. 6 дахь жил (61-72 сар) -5 хувь
- 2.10.6. 7 дахь жил (73-84 сар) -6 хувь
- 2.10.7. 8 дахь жил (85-96 сар) -7 хувь
- 2.10.8. 9 дэх жил (97-108 сар) -8 хувь
- 2.10.9. 10 дахь жил (109-120 сар) -9 хувь
- 2.10.10. 11 дэх жил (121-132 сар) -10 хувь
- 2.10.11. 12 дахь жил (133-144 сар) -11 хувь
- 2.10.12. 13 дахь жил (145-156 сар) -12 хувь
- 2.10.13. 14 дэх жил (157-168 сар) -13 хувь
- 2.10.14. 15 дахь жил (169-180 сар) -14 хувь
- 2.10.15. 16 дахь жил (181-192 сар) -15 хувь
- 2.10.16. 17 дахь жил (193-204 сар) -16 хувь
- 2.10.17. 18 дахь жил (205-216 сар) -17 хувь
- 2.10.18. 19 дэх жил (217-228 сар) -18 хувь
- 2.10.19. 20 дахь жил (229-240 сар) -19 хувь



- 2.10.20. 21 дэх жил (241-252 сар) -20 хувь
- 2.10.21. 22 дахь жил (253-264 сар) -21 хувь
- 2.10.22. 23 дахь жил (265-276 сар) -22 хувь
- 2.10.23. 24 дэх жил (277-288 сар) -23 хувь
- 2.10.24. 25 дахь жил (289-300 сар) -24 хувь
- 2.10.25. 26 дахь жил (301-312 сар) -25 хувь
- 2.10.26. 27 дахь жил (313-324 сар) -26 хувь
- 2.10.27. 28 дахь жил (325-336 сар) -27 хувь
- 2.10.28. 29 дэх жил (337-348 сар) -28 хувь
- 2.10.29. 30 дахь жил (349-360 сар) -29 хувь
- 2.10.30. 31 ба түүнээс дээш жил (361 ба түүнээс сар) -30 хувь

2.10.31. Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн Газрын 1991 оны 13 дугаар тогтоолын хавсралт "Ажилласан хугацааг тооцох журам", Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам"-ыг үндэслэн ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжийн ажилтан ажил олгогчийн зөвшөөрснөөр дотоод, гадаадын академи, их дээд, техник мэргэжлийн сургуульд суралцсан хугацаа, мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх курст суралцсан, үйлдвэрлэлийн сургалтаар мэргэжил эзэмшсэн хугацааг нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч хуульд заасан хувь хэмжээгээр төлөх бөгөөд энэ хугацааг ажилласанд тооцно.

2.11. Байгууллагын жилийн эцсийн ажлын үр дүнг харгалзан тухайн жилийн ашгаас тодорхой хувиар ажилтнуудад жилийн эцсийн үр дүнгийн урамшуулал олгоно. Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд олгохгүй.

2.12. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тавигдах шаардлага, ИНЕГ-ын даргын тушаалаар баталсан "Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох албан тушаалтнуудын жагсаалт"-д үндэслэн гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд олгоно.

2.13. Ажил олгогч нь ажилтнуудын цалин хөлсийг бодит инфляцийн түвшин, ажлын ачаалалтай уялдуулан индексжүүлэх ба Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх тохиолдол тус бүрд нэмэгдүүлсэн хувиар нэмэгдүүлнэ.

2.14. Өнгөрөлтийн нислэг улирлын дунджаар хоногт 250 болон түүнээс дээш тогтмолжсон тохиолдолд үндсэн цалинг 5 хувиар, 350 болон түүнээс дээш тогтмолжсон тохиолдолд үндсэн цалинг дахин 10 хувиар нэмэгдүүлнэ.

2.15. Орон нутгийн салбар, нэгжүүдэд ажиллаж буй ажилтнуудад Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын дагуу орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 20%-иар тооцож сар бүр төсөвт тусгаж хэрэгжүүлнэ. (2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.)

2.16. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, үндсэн цалингийн 40 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний үр дүнгийн нэмэгдлийг сар бүр олгож болно.

2.17. Үндсэн цалингийн сүлжээ, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговор, нөхөн төлбөрийн хэмжээг төсвийн төсөл боловсруулахаас өмнө жил бүр хэлэлцэн хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж байна.

Гурав. Нийгмийн хамгаалал


3.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжид ажилласан жилээс хамааруулж:

3.1.1. 6 сараас 2 жил хүртэл ажилласан бол 1 сарын;

3.1.2. 2 жилээс 5 жил хүртэл ажилласан бол 3 сарын;

БҮРТГЭВ № 91

ХАН-УУЛ ДУУРСГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗӨВШӨӨРСНӨӨР



2024 оны 07 сарын 02

- 3.1.3. 5 жилээс 10 жил хүртэл ажилласан бол 6 сарын;
- 3.1.4. 10 жилээс 15 жил хүртэл ажилласан бол 9 сарын;
- 3.1.5. 15 жилээс 20 жил хүртэл ажилласан бол 18 сарын;
- 3.1.6. 20 жилээс 25 жил хүртэл ажилласан бол 21 сарын;
- 3.1.7. 25-аас дээш жил ажилласан бол 24 сарын дундаж цалинтай тэнцэх тэтгэмж нэг удаа олгоно.

3.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.2 дахь хэсэгт заасан үндэслэл буюу мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болсон нь тогтоогдсон (энэ тухай ажилтанд өмнө нь анхааруулж, мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлээ сайжруулах боломжит хугацаа олгоно. Ажлын дадлага, туршлага, хэрэгцээ шаардлагыг харгалзан ажилтантай харилцан тохиролцож таарч тохирох өөр ажлын байр санал болгоно) ажилтанд ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжид ажилласан жилээс хамааруулж:

- 3.2.1. 6 сараас 2 жил хүртэл ажилласан бол 1 сарын
- 3.2.2. 2 жилээс 5 жил хүртэл ажилласан бол 2 сарын
- 3.2.3. 5 жилээс 10 жил хүртэл ажилласан бол 3 сарын
- 3.2.4. 10 жилээс дээш жил ажилласан бол 6 сарын дундаж цалинтай тэнцэх тэтгэмж нэг удаа олгоно.

3.3. Ажилтан тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, тэтгэвэрт гарах үед ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжид ажилласан хугацаанаас хамаарч дараах тэтгэмжийг тэтгэвэр тогтоолгосон нөхцөлөөр нь тооцон нэг удаа олгоно.

3.3.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон бол:

3.3.1.1. 6 сараас-2 хүртэл жил ажилласан бол 1-2 сарын (ажилласан жилийг тэтгэмж олгох сар гэж ойлгоно);

- 3.3.1.2. 2 жилээс 5 хүртэл жил ажилласан бол 3 сарын;
- 3.3.1.3. 5 жилээс 10 хүртэл жил ажилласан бол 9 сарын;
- 3.3.1.4. 10 жилээс 15 хүртэл жил ажилласан бол 18 сарын;
- 3.3.1.5. 15 жилээс 20 хүртэл жил ажилласан бол 24 сарын;
- 3.3.1.6. 20 жилээс 25 хүртэл жил ажилласан бол 30 сарын;
- 3.3.1.7. 25-аас дээш жил ажилласан бол 36 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

3.3.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон бол:

- 3.3.2.1. 10 хүртэл жил ажилласан бол 12 сарын;
- 3.3.2.2. 10 жилээс 15 хүртэл жил ажилласан бол 21 сарын;
- 3.3.2.3. 15 жилээс 20 хүртэл жил ажилласан бол 27 сарын;
- 3.3.2.4. 20-иос дээш жил ажиллан ажлаас чөлөөлөгдсөн бол 36 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно. /Тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа ажилтанд энэ заалт хамаарахгүй.

3.4. Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.3 дахь хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн хувьд ажилтан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр тогтоогдож хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар бүрэн алдсан бол 3.3 дахь заалт нэгэн адил хамаарна.

3.5. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдан 3.1, 3.2, 3.3, 3.4-д заасан тэтгэмж авсан иргэн ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжид эргэн ажилд орсон тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 60.3, 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсан бол сүүлд ажилласан хугацаанд⁰¹ ногдох тэтгэмжийг тус гэрээний 3.1, 3.2, 3.3, 3.4-д заасны дагуу олгоно. Ажилтны 3.1, 3.2, 3.3, 3.4-д заасны дагуу авсан тэтгэмжийн нийлбэр 36 сараас хэтрэхгүй байна.

ХАЛАГЧИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨЛӨТӨС

3.6. Ажилтан ердийн галлагаатай сууцанд амьдардаг бол шахмал түлш худалдан авахад нь зориулж жилд нэг удаа 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлнэ. (2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.)

3.7. Ажил олгогч нь тухайн жилийн орон сууцны зах зээлийн үнэ ханшийг харгалзан ажилтанд орон сууц худалдан авахад нь зориулж нэг удаа 45,000,000 (дөчин таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.

3.8. Орон сууцны дэмжлэг олгох асуудлыг ҮЭ-ийн байгууллагатай хамтран санал боловсруулах бөгөөд төлөөллийн саналыг харгалзан үзнэ.

3.9. Ажилтан сувилалд жилд нэг удаа хэвтэх болон өдрөөр сувилуулах зардлын үнийн дүнгийн 40 хүртэлх хувийг үйлдвэрчний байгууллага хариуцна.

3.10. Ажилтан анх удаа гэр бүл болсон тохиолдолд холбогдох баримт бичгийг үндэслэн 250,000 (хоёр зуун зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэгийг нэг удаа олгоно. (2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг нэг удаа олгоно.)

3.11. Төрийн одон медалиар шагнуулсан ажилтанд 350,000 (гурван зуун тавин мянга) төгрөгийн гарын бэлэг гардуулна.

3.12. Ажилтанд олгодог хоолны хөнгөлөлтийг ажилласан өдөр бүр 30,000 (гучин мянга) төгрөгөөр тооцож олгоно.

3.13. Сул зогсолтын үед ажилтныг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол үндсэн цалингийн 70 ба түүнээс дээш хувиар олговор олгоно.

3.14. Ажилтан байгалийн давагдашгүй хүчин зүйл, гамшигт өртсөн тохиолдолд ҮЭ-ийн хороо нэг удаа 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн тусламж үзүүлнэ.

Дөрөв. Эх, хүүхэд хамгааллын бодлого

4.1. ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар нэгжийн үндсэн ажилтанд хүүхэд төрүүлж, хүүхэд асрахад нь зориулж өөрийнх нь хүсэлтийг үндэслэн нэг удаа 2,000,000 (хоёр сая) төгрөгийн тэтгэмж олгоно. Энэ тэтгэмж нь нярай хүүхэдтэй ганц бие эцэг, нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхэд нэгэн адил хамаарна.

4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд хүүхдийн эмчилгээний зардалд зориулж гаргасан хүсэлт болон эмнэлгийн магадлагааг үндэслэн жилд 1 удаа 500,000 (таван зуун мянга) төгрөгийн тэтгэмж үзүүлнэ.

4.3. Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан 4 ба түүнээс дээш хүүхэдтэй ажилтан, өрх толгойлсон ганц бие эцэг, эхэд хичээлийн хэрэгсэл авахад нь зориулж 2-16 хүртэлх насны хүүхэд тус бүрт 50,000 (тавин мянга) төгрөгийн тэтгэмжийг 1 удаа олгоно.

4.4. ИНЕГ, ИНҮТ, түүний харьяа салбар нэгжийн ажилтны 0-13 хүртэлх насны хүүхдийн төрсөн өдрөөр холбогдох баримт бичгийг үндэслэн 1 өдрийн, тухайн насны хүүхэд өвчилсөн тохиолдолд эмнэлгийн магадлагааг үндэслэн 3 хүртэлх өдрийн цалинтай чөлөөг тус тус олгоно.

4.5. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ны баярыг тохиолдуулан эмэгтэй ажилтнуудад 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн гарын бэлэг гардуулна.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

4.6. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрийг тохиолдуулан ажилтны 16 нас хүрээгүй хүүхэд бүрт 50,000 (тавин мянга) төгрөгийн гарын бэлэг гардуулна.

Тав. Хөдөлмөр зохион байгуулалт

5.1. Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлэх боломжоор хангана. Хэрэв ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно.

5.2. Харьяа байгууллагын үйлдвэрлэлийн шууд үйл ажиллагаанд оролцдог инженер, техникийн ажилтнууд, орон нутгийн нисэх буудлын холбооны ИТА, нислэгийн удирдагч, нислэгийн мэдээллийн ажилтнууд, нислэгийн төлөвлөлтийн ажилтнууд, шалгалтын нислэгийн багийн ажилтан, нислэгийн журам зохиогч, нислэгийн зураг болон нисэхийн мэдээллийн эмхтгэлийн үйлчилгээнд оролцогч нийт ажилтнууд мөн орон нутгийн нисэх буудлуудад нөхөн хангалтаар ажиллаж байгаа ажилтан нар илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдрүүдэд, мөн шөнийн цагаар ажилласан бол уг ажилтныг нөхөн амруулах ба ажлын зайлшгүй шаардлагаар нөхөн амруулаагүй тохиолдолд календарийн нэг сард 50 хүртэлх цагийн, Газрын үйлчилгээний албаны жолооч нарт 70 хүртэлх цагийн илүү ажилласны нэмэгдэл хөлсийг 2.0 дахин нэмэгдүүлэн тухайн сард нь тооцон олгож, бусад хугацааны амралтыг зайлшгүй биеэр нөхөн эдлүүлнэ. (Ээлжийн зохион байгуулалтаар ажиллах ажилтанд энэ заалт хамаарахгүй.)

5.3. Ажилтанд өглөө ажилдаа ирж, орой буцахад нь нийтийн унаагаар үйлчилнэ.

5.4. Өвлийн цагт хөдөө орон нутагт томилолтоор ажиллаж байгаа жолооч нарт автомашинаа хадгалах гараажийн мөнгийг хүчин төгөлдөр санхүүгийн баримтыг үндэслэн олгоно.

5.5. Ажилтнуудад эрдэсжүүлсэн ус борлуулдаг байгууллагаас эрүүл ахуйн шаардлага хангасан, баталгаатай цэвэр ус худалдан авч хангана.

5.6. Хууль, дүрэмд нийцүүлэн хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг ИНЕГ-т байгуулна.

5.7. Ажилтнуудын ажлын байрны баталгааг хангаж, хүний нөөцийн төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах үүднээс ирээдүйд шаардлагагүй болох, нэмэгдэл ур чадвар шаардагдах, цомхотголд орж болзошгүй ажлын байрны судалгаа гаргаж, өөр ажлын байранд сургаж, шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Зургаа. Мэдлэг, мэргэшил дээшлүүлэх чиглэлээр

6.1. Ажил олгогч нь ажилтныг үндсэн ажлаасаа 1-3 хүртэлх сарын хугацаатай чөлөөлөгдөн байгууллагын захиалгаар (шийдвэрээр) суралцах хугацаанд дундаж цалин хөлсний 70 хувьтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.

6.2. Ажилтан хувиараа суралцах болсон тохиолдолд ажилтны хүсэлтийг харгалзан цалинтай болон цалингүй чөлөө олгож ажлын цагийн зохицуулалтыг хийнэ.

6.3. Байгууллагад 5-аас доошгүй жил ажиллаж байгаа үндсэн ажилтан зөвхөн эрхэлсэн ажлын чиглэлээр мэргэжил, боловсролоо дээшлүүлэхээр суралцах тохиолдолд харьяалах нэгжийн даргын саналыг үндэслэн 2.5 жил хүртэлх хугацаанд цалингүй чөлөө олгоно.

6.4. Ажилтан үндсэн ажил үүргийн чиглэлээр их, дээд сургуульд боловсролоо дээшлүүлэхээр үндсэн ажлаас чөлөөлөгдөлгүйгээр суралцах тохиолдолд сургалтын төлбөрийг төлөхөд тусламж, дэмжлэгийг үзүүлэх ба үндсэн байгууллага, нэгжийн тодорхойлолт, сургалтын байгууллагын нэхэмжлэхийг үндэслэн сургалтын төлбөрийн 70

хувь хүртэлх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно. Тэтгэмжийн хэмжээ нь 3,000,000 төгрөгөөс дээшгүй байна.

Долоо. Эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал

7.1. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын сургалтыг ажил олгогч зохион байгуулах бөгөөд ҮЭ-ийн хороодууд дэмжиж ажиллана.

7.2. Ажил олгогч нь эрсдэлтэй ажлын байрны жагсаалт гарган, түүний дагуу амь нас, эрүүл мэндийн болон хариуцлагын даатгалд даатгуулна.

7.3. Батлагдсан нормын дагуу чанарын шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангана. Мөн ажлын тусгай хувцас, хэрэглэлийг батлагдсан хуваарийн дагуу угааж, цэвэрлэж, засварлаж ариутгах зардлыг байгууллага хариуцна.

7.4. Шаардлагатай тохиолдолд хугацаанаас өмнө ашиглах боломжгүй болсон ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажил олгогч болон ҮЭ-ийн хороо хамтран байгуулсан комисс акт тогтоож дахин олгож болно.

7.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогч нь ажлын шаардлагаар эрүүл мэндийн хугацаат үзлэгт оруулах ажилтнуудын жагсаалтыг батлан эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулж зардлыг хариуцна.

7.6. Биеийн тамир, спортын тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг болон Засгийн газраас 2009 онд баталсан "Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги"-ийн хүрээнд ажилчдыг хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, биеийн тамир, дасгал хөдөлгөөний байнгын хөтөлбөртэй болгох, биеийн тамирын заалаар хангах, эрүүл чийрэг байхад чиглэсэн бусад арга хэмжээг үе шаттайгаар хамтран авч хэрэгжүүлнэ.

7.7. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 335 дугаар тогтоолоор батлагдсан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн тодорхой шаардлагуудыг үндэслэн Иргэний нисэхийн салбарын ажилтнуудад зориулсан дараах байгууламжийн ашиглалтыг хариуцан явуулж, ажилтнуудыг хамруулах ажлыг зохион байгуулна. Үүнд:

1. Спорт заал,
2. Усан бассейн,
3. Чийрэгжүүлэх, бялдаржуулах тоноглогсон танхим,
4. Аэробик, фитнесийн тоноглогсон танхим

7.8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг томилон ажиллуулах ба комиссын бүрэлдэхүүнд Үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг оруулна.

7.9. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх болон үйлдвэрлэлийн ослын мөрөөр авах хариу арга хэмжээний зардлыг ажил олгогч жил бүр төсөвлөж, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг ҮЭ-ийн хороотой хамтран хэрэгжүүлнэ.

Найм. ҮЭ-ийн эрхийг хангах талаар

8.1. ҮЭ-ийн хороодыг ажиллах нөхцөл бололцоогоор (өрөө, хурал, уулзалт хийх байр, мэдээлэл өгөх боломж, албан конторын тоног төхөөрөмж, шаардлагатай судалгаа, мэдээлэл) хангана.

8.2. ҮЭ-ийн гишүүдийн татварыг ажилтны саналыг үндэслэн сар бүр цалингаас бэлэн бусаар хурааж, ҮЭ-ийн хорооны дансанд шилжүүлж хуримтлуулна.

БҮРТГЭВ № 71

ХАЛАГЧИЙН
ҮЙЛНИЛГӨӨНИЙ ХЭЛТЭС

БҮРТГЭВ № 71
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
Хоршотог

8.3. ҮЭ-ийн сонгуультнууд болон гишүүдээс жилд нэг удаа 2 хүнийг Олон улсын болон салбар, орон нутгийн хурал зөвлөлгөөнд оролцоход нь ажлаас цалинтай нөлөө олгож, зардлыг олгох талаар дэмжлэг үзүүлнэ.

8.4. ҮЭ-ийн сонгуультнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулалт цалин хөлс олгох, аливаа арга хэмжээнд нийт ажилтнуудын нэгэн адил хамруулна.

8.5. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон ажилтнуудын эрх ашигтай холбогдох асуудлаар аливаа шийдвэр гаргахдаа ҮЭ-ийн хороо, салбарын ҮЭ-үүдийн холбоонд урьдчилан мэдэгдэж, санал авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий хурал, зөвлөгөөнд ҮЭ-ийн төлөөллийг оролцуулна.

Ес. Гэрээний хэрэгжилт, хяналт, хүлээх үүрэг хариуцлага

9.1. Хамтын гэрээний харилцан тохиролцсон асуудлыг хугацаанд нь биелүүлэх үүргийг талууд харилцан хүлээх ба талууд биелэлтийг хангахад хяналт тавин ажиллана.

9.2. Гэрээний хэрэгжилтийг талууд хагас, бүтэн жилээр дүгнэж мэдээллийг нийт ажилтнуудад хүргэнэ.

9.3. ҮЭ-ийн хороодууд ИНЕГ, ИНҮТ-ийн нийт ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалагчийн хувьд хамтын гэрээнд орсон асуудал бүрийг хугацаанд нь биелүүлэх, биелүүлэхийг шаардах, биелэлтийн явцыг ИНЕГ, ИНҮТ-ийн удирдлагад болон хамт олонд мэдээлнэ.

9.4. Ажил олгогчийн зүгээс зохион байгуулж байгаа олон нийтийн үйл ажиллагаанд хамт олныг идэвхтэй хамруулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар Үйлдвэрчний эвлэл идэвх санаачилгатай ажиллана.

9.5. ИНЕГ, ИНҮТ-ийн харьяа салбар нэгжүүдийн тухайн жилийн ажлыг даргын зөвлөл дүгнэхдээ хамтын гэрээ, Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн биелүүлж буйг харгалзах гол үзүүлэлтийн нэг болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Ч.ОДГЭРЭЛ
26285436 - 1114287926

ГИШҮҮД:
ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
З.ТУЯА

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Д.ХАТАНБААТАР
26285436 - 1119287926

АЖИЛТНЫГ ТӨЛӨӨЛЖ:
ШАЛГАЛТЫН НИСЛЭГ, ЗУРАГЛАЛЫН
АЛБАНЫ АЖИЛТНЫ ҮЭ-ИЙН
ХОРООНЫ ДАРГА
Х.ГАНСҮХ
26285436 - 1114287926

ГИШҮҮД:
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН АЖИЛЛАГСДЫН ҮЭ-ИЙН
ХОРООНЫ ДАРГА
Б.ЭНХ-АМГАЛАН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН АЖИЛТНЫ ҮЭ-ИЙН
ХОРООНЫ ДАРГА
Б.ЗОЛБОО

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ДАРГА

[Signature]
Э.ТӨРБЯАР

"БУЯНТ-УХАА" ОЛОН УЛСЫН
НИСЭХ БУУДЛЫН МЕНЕЖЕР

[Signature]
Б.АЛТАНТУЯА

ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ,
ШАТАХУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА

[Signature]
Н.БАТТӨР

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

[Signature]
Б.СЭР-ОД

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН

[Signature]
Ө.МАРАЛМАА

ИНЕГ-ЫН ХОЛБОО, НАВИГАЦИ
АЖИГЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЖИЛЧДЫН ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА
ДАТАРСАЙХАН

[Signature]
ДАТАРСАЙХАН

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЖИЛЧДЫН
ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА

[Signature]
Р.ОЧБАЯР

ИНЕГ-ЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ АЖИЛЧДЫН
ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА

[Signature]
Н.ДҮГЭРЖАВ

ИНЕГ-ЫН ХАРЬЯА НИСЭХИЙН
МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА

[Signature]
Р.БОЛОРМАА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
МТХГТАҮЭ-ҮҮДИЙН ХОЛБООНЫ
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ-МЭРГЭЖИЛТЭН

[Signature]
Б.НОМИН-ЭРДЭНЭ

БҮРТГЭВ № 91...
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛТЭС
[Signature]
2024 оны 07 сарын 02 нь өдөр

ИНЕГ
ХАНА